



БЯАН-ӨЛГИЙ АЙМАГ
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/170


Рашаант

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, Сум дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн журмын 6 дугаар бүлгийн 6.2 дахь, Сумын 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжсэн 1-р багийн бэлчээрийн гар худаг гаргах /2 газарт/ ажлыг хүлээн авах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажил, нийлүүлсэн бараа материалыг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч дүгнэлт гаргаж, тайлан балансанд тусгаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.
3. Ажлын хэсгийн үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /С.Аманкелд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.СЕРИКБОЛ